



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/905

Хэрлэн сум

Ахмад настныг асруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 8 дугаар зүйлийн 8.3.3, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, Нийгмийн хамгааллын сайдын 2008 оны 139 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан Төрөлжсөн асрамжийн газарт үйлчлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журмын 2.4.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын Бэрх хотын иргэн Гомбожавын Дугарыг /СФ40110511/ өөрийн гаргасан хүсэлт, хууль ёсны асран хамгаалагчгүй байдлыг нь харгалзан үзэж Улаанбаатар хотын "Ачлалт хүүхдүүд" Төрийн бус байгууллагын асрамжийн газарт асруулсугай.
2. Дээрх иргэнтэй холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, "Ачлалт хүүхдүүд" төрийн бус байгууллагын асрамжийн газарт хүргэн өгч, хяналт тавин ажиллахыг Бэрх хотын Захирагч /Ч.Чинбат/-д даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА